



БАТЛАВ: ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН ДАРГА
Г.ГАНДЭЛГЭР

**“ТЭНГЭРИЙН ДОР ТӨРЖ, ХУУЛИЙН ХҮРЭЭНД АМЬДАРНА” ТӨРИЙН ДЭЭД АЛТАНГАДАС
ОДОНТ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ЖАМБАЛЖАВЫН БАЯНМӨНХИЙН
НЭРЭМЖИТ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АНХДУГААР ОЛИМПИАД**

Зорилго: Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийн хүрээнд зайлшгүй мэдэх шаардлагатай хуулиудын заалтуудыг дэлгэрүүлэх, оролцож түгээн, ойлгож хэрэглэх чадамж төлөвшүүлэхэд оршино.

Зорилт 1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг, нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшүүлэхэд чиглүүлэн олон нийтийн оролцоонд тулгуурлах

Зорилт 2. Шат шатны байгууллагуудын хамтын ажиллагаа, төр, ТББ, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааны менежментийг сайжруулах

Зорилт 3. Баг бүрээс 3 иргэн, байгууллага бүрээс 5 албан хаагч оролцуулан өрсөлдөх чадамжийг өсгөн хамт олон, хамтран оролцогчдоо манлайлагчдыг алдаршуулан урамшуулах /40-60 иргэн/

Зорилт 4. “Төр нийгмийн зүтгэлтэн Ж.Баянмөнх”-ийн алдар хүндийг нийтэд сурталчлах

Зорилт 5. МУ-ын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиудыг судлах аян өрнүүлэх

Хамрах хүрээ: Чандмань-Өндөр сумын төсөвт байгууллага, багууд заасан тооны хүрээнд заавал оролцох, ААН, байгууллага, иргэн тааллаараа оролцох

Хугацаа: Олимпиадын 1-р үе шатыг байгууллага тус бүр зохион байгуулах бөгөөд хугацаа нь 3 сарын 25-ны өдөр зохион байгуулж, 2-р шатанд оролцох хүмүүсээ шалгаруулна.

2-р үе шат нь 4 сарын 01-нд зохион байгуулагдана.

Үйл ажиллагаа:

- ✓ Баг байгууллагын дарга нар оролцогчдын нэрсийг 3 сарын 27-ны өдөр ИТХ-ын ажлын албанд ирүүлнэ.
- ✓ АЗДТГ-ын Хууль зүйн хэлтэсээс битүүмжлэн ирүүлсэн материалыг оролцогчдод түгээнэ
- ✓ Олимпиадад оролцогчдын гар утас, интернэтийн хэрэглээг хязгаарлан дэг тогтооно.
- ✓ Олимпиадын 2-ын даваа болох газар, цагийг баг, байгууллагын дарга нарт утсаар 1 өдрийн өмнө мэдээлнэ.
- ✓ Онооны дарааллаар байр эзэлнэ. Байгууллагууд оролцогчдын нийт онооны дундаж, дурдсан хуулиудын хүрээнд бүтэн ватум цаасан дээр хийсэн комиксын агуулга, үзэмж, хүртээмжээр үзэгчдээс авсан үнэлгээ 2-ын нийлбэрээр байр эзэлнэ.

Шагнал: Тэргүүний оролцогчид 1, 2, 3 дугаар байр мөнгөн шагнал

Тэргүүний байгууллага 100000 төгрөг, цом өргөмжлөл

Тэргүүний оролцогч 1-р байр 50000 төгрөг “Хүндэт өргөмжлөл”

2-р байр 40000 төгрөг “Өргөмжлөл”

3-р байр 30000 төгрөг “Өргөмжлөл”

Байгууллага шалгаруулахад:

-Байгууллага дээрээ зохион байгуулалт хийсэн ажлын удирдамж

-Байгууллагын нийт ажиллагсдын оролцооны хувь

-Тайлан бүрдүүлэлт /зураг, тест, оролцогсдын материал/-ийг харгалзана.



Санаачлагчид:

Ж.БАЯНМӨНХИЙН ГЭР БҮЛ ХҮҮХДҮҮД

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА:

Аймгийн ЗДТГ-ЫН ХУУЛЬЗҮЙН ХЭЛТЭС

Сумын ГХУСАЗСЗ